



ӨМНӨТГӨЛ



Та бүхний амар амгаланг эрэн мэндчилье!

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т өөрчлөлт оруулж, ЦЕГ-ын даргын 2018 оны А/209 дүгээр тушаалаар Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төв, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Шуурхай удирдлагын хэлтсийн орон тоо, төсөвт багтаан “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай

удирдлагын алба”-ыг байгуулсан билээ.

Алба байгуулагдсанаас хойших богино хугацаанд албаны стратеги хөгжлийн үндсэн чиглэл, алсын хараа, эрхэм зорилго, ойрын зорилтыг тодорхойлох, албажуулах, албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шинээр байгуулагдсан Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн хүний нөөцийг бүрдүүлэх, томилуулах, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэхэд голлон анхаарч, “Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” гарган, түүнд тусгагдсан 5 бүлэг 29 ажил, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллалаа.

Албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх ажлын хүрээнд 40 гаруй хууль, дүрэм, журам, эрх зүйн актыг судалж, 101 ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүрэм, дотоод журам, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 12 журам, ажлын байрны 8 тодорхойлолтыг шинээр, ажлын байрны 93 тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлууллаа.

Энэхүү хураангуй тайланд тус албаны харъяа нэгжүүдээс 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлыг тоймлон тусгаж та бүхэнд танилцуулж байна.

Цаашид бид албаныхаа үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, алсын хараа, эрхэм зорилгоо амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг тодорхой үе шаттайгаар төлөвлөж, нэгдмэл бодлого, зорилготойгоор хэрэгжүүлэн ажиллах болно.

Шинээр эмхлэн байгуулагдсан алба, нэгжийн үйл ажиллагааг жигдрүүлэх, бэхжүүлэх ажилд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллаж буй Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, харъяа нэгж, алба, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга нарт Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны нийт хамт олны нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.ЗОРИГТ



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС:

I. Алсын хараа:

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ХӨТӨЧ, МЭРГЭШСЭН,
МАНЛАЙЛАГЧ АЛБА БАЙНА.

II. Эрхэм зорилго:

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДИТ МЭДЭЭЛЭЛД
ҮНДЭСЛЭН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ОНОВЧТОЙ ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАЖ
АЖИЛЛАНА.

III. Үнэт зүйлс:

- НАЙРСАГ ХАРИЛЦАА
- ШУУРХАЙ АЖИЛЛАГАА
- ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ
- МЭДЭЭЛЛИЙН УХААЛАГ ТОГТОЛЦОО
- МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦ
- ЭРЭЛТЭД НИЙЦСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ




I. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба байгуулагдав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т өөрчлөлт оруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/209 дүгээр тушаалаар “...мэдээлэл, дүн шинжилгээ, холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ердийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед шуурхай удирдлага, зохицуулалтад оруулах, жижүүрийн нэгж, бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар, дээд шатны байгууллага, албан тушаалтныг бодит мэдээ, мэдээллээр хангах үүрэг бүхий” Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албыг байгуулсан.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ



1.2. “Мэдээлэл, шуурхай удирдлагын хэлтэс, тасаг байгуулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/212 дугаар тушаалаар зарим алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад “Шуурхай удирдлагын хэлтэс, тасаг”-ыг байгуулсан.

1.3. Албаны үйл ажиллагаанд дагаж, мөрдөх эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэв.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 5 бүлэг, 29 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, албаны үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 40 гаруй эрх зүйн актыг судалж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код 133, 700, 701, 702, 706, 713, 714, 715/ 12 журмыг шинэчлэн, 101 ажлын байрны тодорхойлолтод шинжилгээ хийж, 8 тодорхойлолтыг шинээр, 93 тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж албажуулсан.





Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүрэм”, Албаны даргын 2018 оны А/07 дугаар тушаалаар “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дотоод журам”-ыг тус тус батлан мөрдөж байна.



1.4. “Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн дарга нарын сургалт” зохион байгуулав.



тутам байгуулагдсан Шуурхай удирдлагын тасгийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт ажлын чиглэл хүргүүлж, үр дүнг тооцлоо.

“Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн дарга нарын сургалт”-ыг 2018 оны 09 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд шинэ



1.5. Албаны даргын дэргэдэх зөвлөл байгуулагдаж, тодорхой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/226 дугаар тушаалаар албаны даргын дэргэдэх зөвлөлийг байгуулж, өнгөрсөн хугацаанд даргын зөвлөл 4 удаа хуралдаж, хүний нөөцийн чиглэлээр 28, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх чиглэлээр 28, дотоод ажлын чиглэлээр 11, нийт 67 асуудал хэлэлцсэн бөгөөд албаны даргын 39 тушаал (үүнээс А-12, Б-27) гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.



1.6. Нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн Шуурхай удирдлагын тасгийн үйл ажиллагааг шалган зааварчлав.



Нийслэлийн дүүрэг дэх Цагдаагийн 17 хэлтсийн Шуурхай удирдлагын тасгийн өдөр тутмын үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний шуурхай байдал, чанар, хүртээмж, хууль тогтоомжийн хэрэгжилт, хөтлөгдвөл



зохиох бичиг баримт, бүртгэл, судалгаа, бэлэн байвал зохих эд зүйлс, зэвсэг, тусгай хэрэгсэл, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, байгууллагын аюулгүй байдал, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүй, гаргасан шинэ санал, санаачлага, тэргүүн туршлагыг нэвтрүүлсэн, ажиллах орчин, нөхцөлөө бүрдүүлсэн байдлыг 2018 оны 10 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд шалгаж, үнэлж, дүгнэн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, шаардлагатай зөвлөмж, зааварчилгаагаар хангаж ажиллалаа.

1.7. Нийслэлийн дүүргүүд дэх “Шилдэг тасаг шалгаруулах тэмцээн” зохион байгуулав.



“Шилдэг тохижилттой Шуурхай удирдлагын тасаг” шалгаруулах сарын аяныг зохион байгуулж, дүгнэсэн ба дээрх тасгуудын алба хаагчдын эрх зүйн мэдлэг, авьяас чадварыг сорьсон “Шилдэг тасаг шалгаруулах тэмцээн”-ийг амжилттай зохион байгуулсан.

Нийслэлийн цагдаагийн газрын Удирдлага, зохион байгуулалтын хэлтсээс санаачлан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн дунд





1.8. Ажлын үр дүн, бидний амжилтууд ...




Албаны хэмжээнд 67 алба хаагчийг албан тушаалд томилж, 27 алба хаагчийг чөлөөлж, 1 алба



| | |
|--------------------------|----|
| Цагдаагийн хурандаа | 1 |
| Цагдаагийн дэд хурандаа | 4 |
| Цагдаагийн хошууч | 3 |
| Цагдаагийн ахмад | 18 |
| Цагдаагийн ахлах дэслэгч | 12 |
| Цагдаагийн дэслэгч | 9 |
| Цагдаагийн ахлах ахлагч | 3 |
| Цагдаагийн ахлагч | 3 |
| Цагдаагийн дэд ахлагч | 4 |


хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халж, 57 алба хаагчид цагдаагийн цол олгож, 6 алба хаагч төрийн дээд одон, медаль, 4 алба хаагч Хууль зүй, дотоод хэргийн яамны, 17 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын шагналаар тус тус шагнагджээ.

Алба хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр 46 алба хаагч "А", 119 алба хаагч "В", 16 алба хаагч "С", 3 алба хаагч "D", хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа 13 ажилтан "Хангалттай" үнэлэгдлээ.





замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор боловсруулсан “Алкогол детекешн” инновацийн төхөөрөмж нь ХСИС-ийн Инновацийн шилдэг төсөл шалгаруулах уралдаанд 2 дугаар байр эзлэв.



1.11. Албаны сургалт, соён гэрээрүүлэх ажлын үр дүн:

Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу алба хаагчдад эрх зүйн мэдлэг, ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд ХААИС-ийн Бизнесийн удирдлагын сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, мэдээлэл, судалгааны мэргэжилтнүүдийг чадавхижуулахад чиглэсэн зорилтот сургалтыг зохион байгууллаа.



Мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүй, соёл, урлаг, биеийн тамир, спорт, гоо зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, 100 гаруй арга хэмжээнд давхардсан тоогоор 9242 алба хаагч хамрагдсан байна.



1.12. Биеийн тамир, спорт, уралдаан тэмцээнд гаргасан амжилт:



“Монгол Цагдаа -2018” цогцолбор тэмцээний Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, Буудлагын тэмцээний “ПМ” дасгалын төрөлд мөнгөн медаль хүртэж, Шатрын тэмцээний тусгай байр эзэлж, Хүчний гурван төрөлт, Уулын дугуй, Ширээний теннис, Гардан тулааны тэмцээнд тус тус амжилттай дүн үзүүлэв.





II. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн бүрдүүлэлт:



Цагдаагийн байгууллагын мэдээллийн санг 2,5 сая нэгж бодит мэдээллээр баяжуулав.



Энэхүү сангаас сар тутам статистикийн мэдээ, холбогдох судалгааг бэлтгэж, хэрэглэгчдэд түгээж байна.



Тухайлбал, дээрх санд гэмт хэргийн тараалх 63753, зөрчлийн талаарх 113487, нийт 179214 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 62.9 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 36.4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 0.7 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж, гомдол, мэдээллийн 97.4 хувийг 5 хоногт, 2.6 хувийг 6, түүнээс дээш хоногт шалгаж шийдвэрлэсэн дүнтэй байна.





Цагдаагийн байгууллагад 1,530,349 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 314057 буюу 26.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт зөрчлийн 74.2 хувь нь нийслэлд, 25.8 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт




Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт





Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1084 гомдол, мэдээлэл буюу нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 0.5 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.



2.2. Дүн шинжилгээ, судалгааны ажил:



Монгол Улсын Ерөнхий сайдад 48, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 60, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 59, ЦЕГ-ын дарга, тэргүүн дэд даргад 144, нийт 311 удаагийн цаг үеийн нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн тойм мэдээ, өндөржүүлсэн бэлэн байдал, баяр, амралтын өдрүүдийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээлэл, танилцуулгыг нэгтгэн боловсруулав.

“Хүүхэд, залуучуудыг мансуурах, сэтгэцэд нөлөөлөх төрлийн бодис, архи согтууруулах ундааны зүй бус хэрэглээ, цахим тоглоомд донтохоос урьдчилан сэргийлэх”, “Монгол Улсад 2013-2017 онд насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” сэдэвт

суурь судалгаа, “Нийслэлийн нутаг дэвсгэр дэх эргүүлийн зохион байгуулалт, өргөдөл, гомдлын цахим зураглал болон хууль сахиулах чиглэлээр ашиглах техник, технологи, гадаад орны жишиг туршлага”, “Цагдаагийн байгууллагын ажил, үүргийн давхардал, хийдэл, ажлын цаг ашиглалтын байдалд хийх судалгааны ажлын хүрээнд нутаг дэвсгэр



хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдын долоо хоногийн ажлын дундаж ачаалал болон ажил, үүргийн хувьд үүсч буй давхардал, хийдэл”, “Хэрэг шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачааллын судалгаа, дүн шинжилгээ”, “Оффшор бүсэд хөрөнгө нуун далдлах, түүнтэй тэмцэхтэй холбоотой олон улсын туршлага”, “Олон улсын террорист байгууллагуудын стратеги, тактикийн хувьсал”, “Олон улсын хурцадмал байдлын голомтууд”, “Олон улсын мэдээллийн аюулгүй байдал”, “Мансууруулах бодисын үйлдвэрлэл ба хууль бус эргэлтийн өсөлт” зэрэг гэмт хэргийн нөхцөл байдал, зарим алба, нэгжийн ажлын ачаалал, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, тодорхой төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлуудыг тодорхойлох зорилгоор 19 удаа дүн шинжилгээ, судалгааны ажил хийсэн бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай хамтран **“Хүний амь нас хохирсон хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь”** сэдэвт хэлэлцүүлгийг 12 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд амжилттай зохион байгууллаа.



2.3. Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалт:




Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, байгалийн гамшигт үзэгдэл, гал түймэр, малын гоц халдварт өвчин, ноцтой гэмт хэргийн талаарх 450, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагуудаас ирүүлсэн онц ноцтой гэмт хэргийн талаарх 45, гадаад орнуудын дээд, өндөр зочид, төлөөлөгчдийн хамгаалалтын талаарх 64, жагсаал, цуглааны хамгаалалтын

талаарх 165 мэдээлэл, танилцуулгыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, тухай бүр шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллав.

2.4. Мэдээллийн технологи, харилцаа холбоо:

2.4.1. Мэдээллийн систем, програм хангамж:

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд 11 төрлийн програм хангамж шинээр боловсруулан нэвтрүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээллийг бүртгэх, хохирогч болон холбогдогчийн талаарх мэдээллээр баяжуулах, мэдээллийг хянаж баталгаажуулах, баталгаажсан мэдээллийг хүснэгт болон график хэлбэрээр харах, улсын онц чухал объектуудад гарсан зөрчил, харуул хамгаалалтын алба хаагчдаас гаргасан зөрчил, улсын онц чухал объектод нэвтрэх зөвшөөрөл авсан гадаадын иргэдийн мэдээллийг бүртгэх боломж бүрдсэний дээр Цагдаагийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг





“Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд тавигдах нийтлэг MNS 6285:2011 стандарт шаардлага”, ЦБҮА-ны “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /код 135/ журам”-д нийцүүлэн шинэчилсэн.

2.4.2. Холбоо зохион байгуулалт:

Жагсаал, цуглаан, гэмт хэрэгтнийг эрэн хайх, дайчлан баривчлах 8, Үндэсний их баяр, “Наадам” болон орон нутагт зохион байгуулсан даншиг наадам, гадаадын зочид, төлөөлөгчдийн айлчлал, олон нийтийг хамарсан бусад арга хэмжээ



10, цагдаа, дотоодын цэргийн байгууллага, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан 3 удаагийн сургалт зэрэг 21 арга хэмжээний холбоог амжилттай зохион байгуулж, дүрст мэдээллийг Шуурхай удирдлагын штабт шууд дамжуулж ажиллав.

2.5. Мэдээлэл, шуурхай удирдлага, зохицуулалт:



Гэмт хэрэг, зөрчлийн талаарх 688,812 дуудлага, мэдээллийг хүлээн авч, бүртгэн, хуваарилж, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 108 дугаарт хүүхдийн амь нас хохирсон болон хүүхдийн эрх зөрчигдсөн тухай 642 мэдээллийг дамжуулж, тус төвөөс 102 тусгай дугаарт ирүүлсэн 2023 дуудлагыг хүлээн авч, хамтран ажиллав.



Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн <http://102.police.gov> дотоод цахим хуудсанд хулгайлах гэмт хэргийн дуудлагын шийдвэрлэлтийн зөрчлийн талаар 212, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг олон давтамжтай ирүүлсэн утасны дугаар, хаягийн 264 мэдээллийг байршуулж, хяналт тавьж байна.

Төв болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс ирүүлсэн нөхцөл байдлын болон онцлог мэдээллүүдээс Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабт 8190, Эрүүгийн цагдаагийн албаны жижүүрт 1976, Мөрдөн байцаах албаны жижүүрт 1816 мэдээллийг тус тус дамжуулж, Шуурхай





удирдлагын хэлтэс, тасаг хооронд шилжүүлсэн 567 дуудлага, мэдээлэлд хяналт тавьж ажилласан.



Хулгайн 31340, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн 65891 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 14685, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 42540, нийт 57225 иргэнтэй холбогдон, хулгайлах дуудлагын шийдвэрлэлтийн зөрчлийн 212, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага давтан бүртгэгдсэн 264 хаягийг сүлжээнд байршуулж, 476 албан

бичгийг төлөвлөн холбогдох дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлсэн.

Орон нутаг болон дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс зарлуулахаар ирүүлсэн сураггүй алга болсон болон олдсон хүн /хүүхэд/, хулгайд алдагдсан тээврийн хэрэгсэл, эд зүйлс, мал зэрэг нийт 222 мэдээллийг Цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр зарлан мэдээлсэн байна.

Шуурхай удирдлагын нэгжүүд хооронд шилжүүлсэн 567 дуудлагад хяналт тавьж, орон нутгаас ирүүлсэн 7131 гэмт хэргийн мэдээг авч, сүлжээнд байршуулсан.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс санаачлан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9, Цагдаагийн албаны тухай хуулийн 65, Аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу 241 хуулийн этгээдэд албан мэдэгдэл хүргүүлж, 27 аж ахуйн нэгжид 32 камер шинээр тавиулж, 17 аж ахуйн нэгжийн 78 ширхэг камерыг цагдаагийн байгууллагын сүлжээнд холбож, 119 аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа камерын чиглэлийг өөрчлөн, тухайн орчинд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн нь үр дүнгээ өгч байна.



Сүхбаатар дүүргийн 11-18 дугаар хороонд суурилуулж байгаа 88, Баянзүрх дүүргийн 8, 18, 19, 23, 24, 28 дугаар хороонд суурилуулж байгаа 40, Хан-Уул дүүргийн 4-8 дугаар хороонд суурилуулж байгаа 115, нийт 243 камерыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож, хяналт тавьж байна.



2.6. Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах:

Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн злэг, үйлчилгээ 2039, засвар 1368, өргөтгөл, суурилуулалт 362 удаа хийж, дуудлага, мэдээллийн бүртгэлийн E1N системийн тогтвортой байдлыг хангаж ажиллав.



байна.

Дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн Шуурхай удирдлагын тасаг, Эрүүлжүүлэх, саатуулах байр, дэд хэсгүүдэд суурилуулсан 73 аналог суурин станц, 19 тоон суурин станц, 9 чанга яригч, 41 гар станц, 14 машины станц, 41 компьютерын техник хэрэгсэл, 24 дотоод сүлжээний тоног төхөөрөмжид үзлэг, үйлчилгээ хийсэн

Улаанбаатар цагдаагийн хүрээний зарим нэгжийн 584 компьютерт үзлэг хийж, 188 компьютерт үйлдлийн систем, 167 компьютерт хэрэгцээт программ хангамж суулгаж, 62 принтерийг сүлжээгээр холбожээ.



III. САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАНГАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус албаны хэмжээнд батлагдсан төсвийн 100 хувийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 45,1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэв.

Шилэн дансны <http://shilendans.gov.mn>, <http://itc.police.gov.mn> цахим хуудсуудад тус албаны санхүү, худалдан авалтын мэдээллийг 133 удаа /төсөв гүйцэтгэл 42, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт 35, бусад 56/ мэдээлж, иргэний хяналтын тогтолцоог бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэв.



IV. 2018 ОНЫ ТЭРГҮҮНИЙ АЛБА ХААГЧИД:

5.1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Хөдөлмөрийн тэргүүний алба хаагч”, “Ажил, мэргэжлийн шилдэг алба хаагч”-аар дараах алба хаагчид шалгарав.

“ХӨДӨЛМӨРИЙН ТЭРГҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ,
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ АЛБА ХААГЧ”



Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Золжаргал

“АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ШИЛДЭГ
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА
ХААГЧ”



Нийслэлийн цагдаагийн газрын Удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн ерөнхий жижүүр, цагдаагийн дэд хурандаа Д.Батмөнх

“АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ШИЛДЭГ
СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБА ХААГЧ”



Тээврийн цагдаагийн албаны Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэчимэг

“АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ШИЛДЭГ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АЛБА
ХААГЧ”



Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн холбооны инженер, цагдаагийн ахмад Ү.Намсрай



5.2. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Хөдөлмөрийн аварга алба хаагч”, “Ажил, мэргэжлийн аварга алба хаагч”, “Оны онцлох алба хаагч”-ийг шалгаруулж, Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнав.

Албаны даргын 2018 оны “Журам батлах тухай” А/10 дугаар тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аварга алба хаагчийг шалгаруулах журам батлагдаж, харьяа нэгж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдыг шалгаруулав.

5.2.1. Хөдөлмөрийн аварга алба хаагч:

Мэдээлэл, дүн шинжилгээ,
судалгааны алба хаагч



Статистик мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Уянга

Мэдээллийн технологи,
харилцаа холбооны алба
хаагч



МШУТ-ийн Техник ашиглалтын хэлтсийн Телехяналтын ашиглалтын тасгийн ахлах инженер, цагдаагийн ахмад Т.Сайнзаяа

Шуурхай удирдлагын
алба хаагч



Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн ШУТ-ийн мэдээлэл хүлээн авагч-жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ш.Төгсжаргал

5.2.2. Ажил, мэргэжлийн аварга алба хаагч:

Мэдээлэл хүлээн авагч



МШУТ-ийн Шуурхай удирдлагын хэлтэс /102/-ийн мэдээлэл хүлээн авагч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Түвшинжаргал

Жижүүрийн офицер



Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтсийн ШУТ-ийн ахлах офицер, цагдаагийн хошууч Л.Нандинбаатар

Мэдээллийн технологийн
инженер



МШУТ-ийн Техник ашиглалтын хэлтсийн сүлжээний ашиглалт хариуцсан инженер, цагдаагийн ахмад Л.Ганзориг

Холбооны инженер



Дорнод аймаг дахь цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн холбоо, мэдээллийн инженер, цагдаагийн ахмад В.Болормаа



Мэдээлэл судалгааны
ажилтан



Хэрэг бүртгэх албаны
мэдээлэл, судалгаа хариуцсан
чиглэлийн ахлах мэргэжилтэн,
цагдаагийн хошууч Б.Батдаваа

Судалгаа, дүн шинжилгээний
ажилтан



Дүн шинжилгээ, судалгааны
хэлтсийн мэргэжилтэн,
цагдаагийн дэд хурандаа
Ш.Туяа

Захиргаа,
санхүүгийн ажилтан



Захиргааны удирдлагын
хэлтсийн ахлах мэргэжилтэн,
цагдаагийн дэд хурандаа
Б.Баттулга

5.2.3. Оны онцлох алба хаагч:

Хамгийн санаачлагатай алба
хаагч



Мэдээллийн технологи
холбооны төвийн өгөгдлийн
сангийн ахлах инженер,
цагдаагийн ахмад Ж.Хатанзориг

Хамгийн үлгэр жишээ
удирдах ажилтан



Өмнөговь аймаг дахь
цагдаагийн газрын Шуурхай
удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа
Д.Нарангэрэл



АЛБАНЫ ЦААШДЫН ЗОРИЛТ:

- Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны шуурхай байдлын түвшинг дээшлүүлж, иргэн төвтэй цагдаагийн ажил, үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх;

- Хоногийн нөхцөл байдлын мэдээг бүрэн, бодитой нэгтгэн гаргах, удирдлага болон дээд байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох;

- Цагдаагийн байгууллагын цахим мэдээллийн ухаалаг, нэгдсэн тогтолцоог бий болгож, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглах, хайлт, лавлагаа хийх боломжийг нэмэгдүүлэх;

- Судалгаа, дүн шинжилгээний ажилд орчин үеийн арга, аргачлалыг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, түүнд нөлөөлдөг шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж, байгууллагын удирдлагын үйл ажиллагааг мэдээлэл, дүн шинжилгээгээр хангаж ажиллах;

- Мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, “Цагдаагийн байгууллагын дижитал шилжилт”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

- Алба хаагчдын албан үүрэгтээ хандах эрерэг хандлагыг төлөвшүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

---oOo---